



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чингис хот

2023 он

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

“Өндөрхаан итгэл аудит” ХХК-ийн:

Аудитор: Б.Маналсүрэн

Утас: 99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.02.27 № 161

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Жаргалтхаан сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгө 27,833.6 мянган төгрөг, авлага 803.9 мянган төгрөг, бараа материал 66,609.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 591,345.9 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй буюу нийт хөрөнгө 686,592.8 мянган төгрөг байна.

Тайлант онд улсын төсвөөс 518,217.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,164.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 533,499.8 мянган төгрөгийг зарцуулж, 550.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9,156.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: Жилийн эцэст сэлбэг хэрэгслэлийн үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй 1,977.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, төлбөрийн баримтын цахим системд ө.баримтгүй 6,495.1 мянган төгрөгийн худалдан авалт, эзэн холбогдогч нь тодорхойгүй 683.8 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй зэрэг 7,178.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн ба зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

232330211

Бусад асуудлын хэсэг

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулахад анхаарч ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг ханган, бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,296,399.22	95,246,915.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,666,997.73	27,833,624.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,666,997.73	27,833,624.80
3121	Төгрөг	1,666,997.73	27,833,624.80
31211	Төрийн сангийн харилцах	1,666,997.73	27,833,624.80
33	АВЛАГА	35,914,566.12	803,854.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	120,088.00
33200	Төлбөргүй үйлчилгээний авлага	35,230,800.00	-
335	Бусад авлага	683,766.12	683,766.12
3351	Байгууллагаас авах авлага	683,766.12	683,766.12
35	БАРАА МАТЕРИАЛ	35,714,835.37	66,609,436.14
351	Түүхий эд материал	16,516,941.70	32,953,352.80
35130	Эм боох материал	16,516,941.70	32,953,352.80
354	Хангамжийн материал	19,197,893.67	33,656,083.34
35410	Бичиг хэргийн материал	242,000.00	1,032,000.00
35420	Аж ахуйн материал	2,413,400.00	4,614,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,977,800.00
35460	Хүнсний материал	1,920,900.00	2,203,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,621,593.67	23,828,883.34
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	620,508,537.79	591,345,897.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	620,508,537.79	591,345,897.06
392	Биет хөрөнгө	602,918,537.79	573,755,897.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	458,715,200.00	470,563,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,805,015.27)	(55,994,498.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,649,668.00	103,649,668.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,414,833.80)	(58,702,300.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,564,868.62	186,171,396.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,650,466.10)	(94,962,165.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,614,871.01	32,767,393.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,625,429.71)	(11,898,737.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,203,600.00	2,587,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(333,924.96)	(425,858.28)
393	Биет бус хөрөнгө	17,590,000.00	17,590,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,590,000.00	17,590,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	693,804,937.01	686,592,812.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	120,088.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	120,088.00
413	Өглөг	-	120,088.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	120,088.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	693,804,937.01	686,472,724.12
51	Засгийн газрын хувь оролцоо	693,804,937.01	686,472,724.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	372,963,647.00	372,963,647.00
512	Хуримтлагдсан үр дүн	294,478,852.99	287,146,640.10
51210	Өмнөх үеийн үр дүн	186,927,153.34	292,914,892.99
51220	Тайлант үеийн үр дүн	107,551,699.65	(5,768,252.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,362,437.02	26,362,437.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	693,804,937.01	686,592,812.12

Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	638,631,408.80	556,549,665.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,700,802.80	31,882,955.67
120	Нийтлэг татварын бус орлого	81,700,802.80	31,882,955.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,166,300.53	31,882,955.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		319,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,166,300.53	31,563,455.67
120009	Бусад орлого	1,534,502.27	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	556,930,606.00	524,666,710.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,988,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,988,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,334,886.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	137,334,886.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,763,500.00	30,164,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,763,500.00	30,164,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,843,320.00	494,502,710.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,843,320.00	494,502,710.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	531,079,709.15	562,317,918.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,079,709.15	562,317,918.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,870,852.15	561,767,290.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,019,408.77	337,952,015.93
210101	Үндсэн цалин	149,111,855.00	203,044,208.40
210102	Нэмэгдэл	121,816,649.22	103,838,715.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,201,998.55	4,203,000.00
210104	Урамшуулал	26,631,122.00	25,938,345.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,257,784.00	927,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,505,865.50	42,189,584.00
210201	Тэтгэврийн даатгал	27,399,755.85	31,337,834.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,031,058.09	2,725,765.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,847.10	2,180,612.44
210204	Ажилгүйдлийн даатгал	588,090.84	537,639.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,062,113.62	5,407,731.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,725,691.00	27,381,372.00
210301	Гэрэл, цахилгаан	2,990,241.00	2,657,782.00
210302	Түлш, халаалт	21,075,450.00	24,063,590.00
210303	Цэвэр, бохир ус	660,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,521,433.30	24,994,849.00
210401	Бичиг хэрэг	1,328,200.00	1,540,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,892,230.00	18,971,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,270,320.00	1,144,519.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	276,000.00	438,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,900,350.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,671,183.30	-
210408	Бараа материал акталсны зардал	83,500.00	-
2105	Нормативт зардал	60,770,734.08	64,393,067.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,887,209.08	45,473,684.90
210502	Хоол, хүнс	12,089,525.00	17,220,383.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	794,000.00	1,699,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,469,002.27	2,483,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	239,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	-
210604	Урсгал засвар	6,430,002.27	2,483,200.00
2107	Томилголт, зочны зардал	2,200,000.00	4,701,500.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	4,701,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273,338.00	392,271.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	147,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,750.00	111,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210807	Газрын төлбөр	73,688.00	67,421.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,385,379.23	57,279,430.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	958,400.00	4,689,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,426,979.23	52,589,930.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,208,857.00	550,628.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	202,009.00	550,628.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,009.00	550,628.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,848.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,848.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,551,699.65	(5,768,252.89)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	107,551,699.65	(5,768,252.89)

Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	537,529,862.00	560,217,010.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,616.00	319,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	120,616.00	319,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	319,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		319,500.00
120009	Бусад орлого	120,616.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	537,409,246.00	559,897,510.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,988,900.00	74,218,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,988,900.00	74,218,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,813,526.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,813,526.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,763,500.00	30,164,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,763,500.00	30,164,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,843,320.00	455,514,710.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,843,320.00	455,514,710.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	510,553,864.27	527,344,882.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	510,553,864.27	527,344,882.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,925,007.27	526,794,254.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,019,408.77	337,943,615.93
210101	Үндсэн цалин	149,821,168.00	203,035,808.40
210102	Нэмэгдэл	121,816,649.22	103,838,715.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,201,998.55	4,203,000.00
210104	Урамшуулал	25,921,809.00	25,938,345.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,257,784.00	927,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,505,865.50	42,189,584.00
210201	Тэтгэврийн даатгал	27,399,755.85	31,337,834.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,031,058.09	2,725,765.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,847.10	2,180,612.44
210204	Ажилгүйдлийн даатгал	588,090.84	537,639.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,062,113.62	5,407,731.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,334,441.00	27,381,372.00
210301	Гэрэл, цахилгаан	2,990,241.00	2,657,782.00
210302	Түлш, халаалт	26,684,200.00	24,063,590.00
210303	Цэвэр, бохир ус	660,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,206,960.00	26,459,349.00
210401	Бичиг хэрэг	1,190,200.00	2,330,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,298,590.00	18,971,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,270,320.00	1,144,519.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	451,000.00	438,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,996,850.00	3,574,850.00
2105	Нормативт зардал	82,775,894.00	73,503,063.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,501,184.00	50,123,180.00
210502	Хоол, хүнс	12,167,710.00	17,510,883.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,107,000.00	5,869,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,399,100.00	9,828,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	172,100.00	3,397,800.00
210602	Тавилга	-	370,000.00
210604	Урсгал засвар	3,227,000.00	6,060,700.00
2107	Томлолт, зочны зардал	2,200,000.00	4,701,500.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	4,701,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273,338.00	392,271.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	135,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,750.00	129,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	60,000.00
210807	Газрын төлбөр	73,688.00	67,421.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,210,000.00	4,395,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,210,000.00	4,395,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,628,857.00	550,628.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,420,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,420,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	202,009.00	550,628.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,009.00	550,628.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,848.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,848.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,975,997.73	32,872,127.07
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,309,000.00	6,705,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,309,000.00	6,705,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,309,000.00	6,705,500.00
223001	Бусад хөрөнгө	25,309,000.00	6,705,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,309,000.00)	(6,705,500.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,666,997.73	26,166,627.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,666,997.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,666,997.73	27,833,624.80

Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	186,927,153.34	586,253,237.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	186,927,153.34	586,253,237.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	107,551,699.65	107,551,699.65
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	294,478,852.99	693,804,937.01
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	294,478,852.99	693,804,937.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	294,478,852.99	693,804,937.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	(1,563,960.00)	(1,563,960.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,768,252.89)	(5,768,252.89)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,963,647.00	26,362,437.02	287,146,640.10	686,472,724.12

Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
 2022 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	548,381,100.00	533,499,754.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	548,381,100.00	533,499,754.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,381,100.00	533,499,754.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	345,827,100.00	337,943,615.93
210101	Үндсэн цалин	192,373,500.00	203,035,808.40
210102	Нэмэгдэл	121,246,000.00	103,838,715.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,082,000.00	4,203,000.00
210104	Урамшуулал	25,926,000.00	25,938,345.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,199,600.00	927,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,910,300.00	42,189,584.00
210201	Тэтгэврийн даатгал	31,595,700.00	31,337,834.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,842,600.00	2,725,765.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,000.00	2,180,612.44
210204	Ажилгүйдлийн даатгал	568,500.00	537,639.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,629,500.00	5,407,731.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,927,600.00	27,381,372.00
210301	Гэрэл, цахилгаан	3,200,000.00	2,657,782.00
210302	Түлш, халаалт	24,063,600.00	24,063,590.00
210303	Цэвэр, бохир ус	664,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,914,300.00	26,459,349.00
210401	Бичиг хэрэг	2,345,000.00	2,330,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,972,000.00	18,971,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,375,400.00	1,144,519.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	554,800.00	438,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,667,100.00	3,574,850.00
2105	Нормативт зардал	75,616,700.00	74,213,063.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,207,900.00	50,833,180.00
210502	Хоол, хүнс	17,517,100.00	17,510,883.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,891,700.00	5,869,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,480,600.00	15,440,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,935,400.00	4,899,300.00
210602	Тавилга	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	6,545,200.00	6,540,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,754,700.00	4,701,500.00
210702	Дотоод албан томилолт	5,754,700.00	4,701,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,164,600.00	392,271.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	612,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	192,100.00	135,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,600.00	129,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	60,000.00
210807	Газрын төлбөр	216,500.00	67,421.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	875,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,785,200.00	4,779,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,785,200.00	4,779,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	548,381,100.00	559,666,382.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,164,000.00	29,613,372.00
132001	Орон нутгийн төсвөөс	30,164,000.00	29,613,372.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	441,225,800.00	529,733,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	441,225,800.00	529,733,510.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА	76,991,300.00	319,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,991,300.00	319,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,666,997.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,833,624.80

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

Аудитаар нийт **9,156.7** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **1,977.8** мянган төгрөгийн 1 албан шаардлага, **7,178.9** мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

Жилийн эцэст сэлбэг хэрэгслэл 1,977.8 мянган төгрөгийн материалын үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл. “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого”, 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг зөрчсөн ба “*Үнэн зөв байдал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө, материалын тооллогыг бүрэн хийж, тооцоо бодож баталгаажуулах, албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

5.3.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 6,495.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх., зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж хүргүүлж байна.

5.3.2. Эзэн холбогдогчгүй авлагыг шийдвэрлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг: 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалт, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид авлагын насжилтын судалгаа гаргаж шийдвэрлүүлэх, зөвлөмж хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт дүн									
----------	--	--	--	--	--	--	--	--	--

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			